

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засаг сэргэж байгаагаас үүдсэн үнийн өсөлтийг зорилтот түвшинд барих, боомтын сэргэлтийг эрчимжүүлэн экспортоос орох төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрт чиглүүлэх, дэд бүтцийг сайжруулах, төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулан төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн ирэх онд өрийн дээд хязгаарыг бууруулах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир улсын төсвийн алдагдлыг бууруулж, алдагдалгүй төсөв батлах боломжтой эсэх талаар, ирэх онд шинээр хөрөнгө оруулалтын зардлыг 2023 оны төсөвт тусгаагүй хэдий ч нийт зарлагын хэмжээ нэмэгдсэн талаар, мөн татварыг шударгаар тайлагнах нөхцөл бололцоог бүрдүүлж, далд эдийн засгийг ил болгох, төлбөрт таавар, бооцоот тоглоомын газруудыг оруулж ирэх замаар шинэ орлогын эх үүсвэр олох боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан гишүүн төрийн албан хаагчдын орон тоо, нийт цалингийн зардал хэд болж байгаа, халамжийн зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувийг эзэлдэг талаар бусад улс оронтой харьцуулсан судалгаа байгаа эсэх, өрийн дээд хязгаарыг цаашид хэрхэн бууруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тусгагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 5 хувьд, хэрэглээний үнийн өсөлтийн түвшинг 8 хувьд хүрэхээр тооцсон нь бодитой эсэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих бодлогын арга хэмжээ нь ирэх оны төсөвт шууд нөлөөлөх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай тогтоолын төсөлд тусгасан Хөгжлийн банкны зээлийн төлөлтийг дахин санхүүжүүлэх заалтыг хасах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин хос төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэхийг дэмжиж байна, цаашид эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН